

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ганжууржавын Цэндсүрэн	Дугаар	L039
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Хэнтий аймгийн Жаргалтхаан сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жаргалтхаан сумын Баатарын дацан буюу Пунцогтэгчинлин хийд	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 010
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	УВ 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 10-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Баатарын дацан буюу Пунцогтэгчинлин хийд

Би 5 настайдаа Баатарын дацанд суугаад 8,9-тэй хар болсон. 1927 (1937) онд дацангийн лам нар хөдөө гараад 1928 онд (1938) бариа тавиа болоод багш маань ч баригдаад явсан. Би ч сургуульд хөөгдөөд явсан. 1990 онд хурал гараад лам боллоо. Хэнтий аймгийн Гүндгаравлин хийдэд хураад, мөн манай сумд ч хурал гарсан. Тэгсэн манай сумын хурал ч байхгүй боллоо. Тэгээд хотод ирсэн. Одоо Ламрим хийдэд хүрж байгаа.

Манай сумын зүүн хойно Тахилтын хийд гэж байсан. Зүүн урагшаа Цагаан нуурын суварга гэж бий. Хүүхэн хутагтын хийд их сайхан хийд байсан гэдэг. Их олон зоч нартай. Наймаа маймаа ихтэй хийд байсан гэсэн.

Баатарын дацан бол Баатарын хошууны хийд. 500-аад ламтай, 7 дуган, 4 отогтой байсан. Баатарын дацан сүүлийн байгаа газартаа нэлээн хойно очсон. Тэнд очихоосоо өмнө Угалз гээд өндөр уулын өвөрт байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болтой байгаа юм. Мөн Хөндлөн гэдэгт байсан. Одоо тэр дацангийн суурь байгаагаасаа баруун хойш голын хажууд зүгээр нэг тал газар байсан юм. Тэр урагшаа Баянцогт уулын зүүн талд байсан. Хамгийн сүүлд Товонгийн ард төвлөсөн юм билээ. Байгуулагдсан он цагийн тухай мэдэхгүй. Баатарын дацан дөрвөн отогтой байсан. Дөрвөн отгийн дунд нь Ганжуур гэсэн хоёр том дуган байсан. Нэг нь сүмтэй дуган гэж өндөр дуган байсан. Тэрэнд хайлан хурна. Нөгөө нь Батцагаан гэдэг дуган урд нь байсан. Тэнд намрын Хангал хурна. Дөрвөн отгууд нь дандаа өөр өөрсдийн Хангал, сахиусаа хурдаг байсан. Баруун урдах отгийг Суварга, Баруун хойд отгийг Өрлүүд, Зүүн хойд отгийг Тайж нар, Зүүн урд отгийг Голбог отог гэдэг байсан. Голбог отгийн үнзад нь Цэнджав гэдэг хүн. Дамдинжав гэдэг гэсгүй байсан. Голбог отог хамгийн олон ламтай том нь байсан. Суварга отог их цөөхөн ламтай байсан. 20, 30 орчим байсан байх. Өрлүүд, Тайж нарт 100 орчим, Голбогт 200-аад лам байсан байх. Би Голбог отгийн лам байсан. Одоо Голбог отгийн дуганын сууринд суварга босгосон байгаа. Голбог отог Таван хаан сахиустай байсан. Сар бүрийн 25-нд Лхамаа хурна. Таван хаанаа тахина. Лхамыг өвчин зовлон аливаа муу бүхнийг хөөж зайлуулах гэж хурна. 29-нд бусад хийдүүдийн адил Сахиус, Гончоо Лхаасам хурдаг байсан. Манай хийд Чойргүй байсан. Отог бүр дуганатай. Сандаг хамба гэж том хүн байсан. Хошуу даяараа тэр хүний шавь. Тэр хамба Чойр гаргаад хэрэггүй гэсэн юм гэнэлээ. Манай нутгийн лам нар Хүрээнд Намдолин аймагт харьяалагдаж байсан. Тэнд мундаг мундаг эрдэмтэй лам нар байсан. Гэгээний долоон цоржийн нэг Дугаржав цорж гэж байсан. Тэр хүн манай нутгийн хүн байсан юм. Дугаржав цоржийг Намдолин аймгийн Улаан шуурга гэж байсан юм гэнэ лээ. Тэр лам манай Баатарын хийд дээр очиж байсан юм. Шавь нар нь манай хийд дээр байсан юм байна лээ. Би хүртэл хажууд нь дагаад жаахан сэнжтэй олбогийг нь бариад явж л байсан юм. Би уншлагаа төгсчихөөд Харанга, Хангал, Манла үзэж байсан.

Хэнтий аймагт хийд сэргээгдэхэд хамбаар нь очиж байсан Намдолин аймгийн Гомбожав гэж манай багш байсан. Мөн Дашчоймбэлийн гавж Лувсаншарав гэдэг хүн миний багш байсан. Номч Намхай лам гэж хүрээнд сууж байсан. 20 гаран настайдаа баригдсан гэсэн. Уг нь Хэрээ Хөхөлд гарч тодроод Хүрээнд сууж байсан юм гэсэн. Тайжийн Дамдин гэлэн гэж Богдын мэлмийг үлээж байсан хүн байсан гэж байгаа. Тайж угсаатай хүн байсан юм шиг байгаа юм. Богдын нүдэнд тарни өргөж байсан. Богдоос миндаг тушаал хүртэж байсан. Дацан дээрээ алтан малгайтай илбэнхэн хүрэмтэй явдагсан. Тэднийх жороо цоохор адуутай айл байсан юм. Тэгээд жороо цоохор морь уначихаад л явна. Тэдний байшин хашаа хийд дээр байсан. Олон гавж нар байсан. Дашчойнбэл, Гунгаачойлин хоёрын гавж нар олон байсан. Мөн олонд нэртэй Буриад Дэлэн гэдэг хүн байсан. Нүдний цагааныг нэг үлээгээд л арилгана. Тийм эрдэмтэй сайн лам байсан юм. Тэр хүн баригдалгүй үлдсэн. Тэр ламд тойн лам гэдэг хүн хэлсэн гэж байгаа юм. За цөвүүн цаг ирнэ ээ. Тэгэхэд чи зүсээ хувилгаад зүрхээ шомбойлгоод суугаад байгаарай гэж хэлсэн гэнэ. Тэгээд тэр лам ерөөсөө гутлаа тайлаад орон дээрээ сөгдөөд суучихдаг байсан. Миний толгойдээр яр гараад дараа нь тэр ламд бараалхаж байсан. Дацангийн суурин дээр манай нэг байшин байсан. Тийшээ орох нэрээр очиж уулзаж шавь орж байсан. Буриад Дэлэн үхэр тэрэг хөтлөөд Алтанбулаг, Эрээнцав орж байсан. Баригдахгүй гэж тэгж явж байсан юм уу даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хурал ном хаагдахад Хүрээнд сууж байсан хорь гаруй чойрын гэвш нар Баатарын дацангаас урагшханаа Байц гэдэг уулын ойролцоо байдаг байсан. Бариа тавианаас зугтаасан, энэ тэр болсон. Алтанбулаг, Эрээнцав явж байгаад үлдчихсэн тийм хүмүүс юм байна лээ. Баригдаагүй. Тэгээд тэндээ байж байгаад нас барсан. Тахилтын хийд чинь цөөхөн ламтай, онцын айхтар сайн лам байгаагүй гэж ярьдаг байсан.

Манай Баатарын хийд өвөл зунгүй Цогчэнтэй намар 4 отог дөрвүүлээ Хангал хурна. Намар л Хангал хурж байсан юм. Хурал дээр хувинтай цав орж ирж байхад л уур гараад байдаг байсан юм. Бэрээвэнгийн цам ч тэр, Хутагтын цам ч гэсэн тэр намар л болж байсан санагддаг юм. Намайг цамд аав эжий хоёр авч явах гэхээр багш минь хурал нь олдохгүй болно гээд явуулдаггүй байсан юм. Хуралдаа хурсан нь дээр гээд. Лам нарыг чинь олон жилийн урдаас данслаад судалгаа аваад байсан юм байна лээ. Тэгээд дансаа барьж байгаад л бариад бариад авчихсан юм.

Жас нь малтай л байсан. Дуганууд нь хятад маягийн дуганууд байсан байх. Тийм том байгаагүй. Жижиг л байсан.

Лам нар чинь баригдах нь баригдаж дуусаад тэгээд артельд орох нь ороод гар үйлдвэрт монгол гутал хийж байсан. Тахилтын хийдийн тэнд нэг хоршоо байсан юм энэ лээ. Манай аав тэр хоршооны нягтлан хүн байсан. Тайж угсаатай гээд баригдсан. Манайх хамаг юмаа хураалгасан. Манай аав байхдаа манайх ганц хүүтэй хүүгээ сургуульд оруулна гээд саналаа өгчихсөн байсан. Аав баригдаад, би эжийтэйгээ хоёулхнаа нэг үнээ, тав зургаан хоньтой үлдэж байсан. Лам нар 1936, 1937 оны намар л дацангаасаа хөдөөлчихсэн юм байна лээ. Тэгээд тараад алга болсон. 1937 оны өвөл дацангийн суурин дээр гал гараад байсан. Тэгсэн ном судрыг нь шатааж байсан нь тэр байсан. Хийдийн урд руу хогийн газар байсан. Тэнд шатаачихсан юм гэсэн. Шөнө шатаадаг байсан. Тэгээд хавар нь юу ч байхгүй болсон. Айлын байшин л үлдсэн. Дуган энэ тэрийг чинь буулгаад буулгаад аваад явчихсан. Хурлын сайхан сайхан мөнгөн гандан эд нарыг чинь байшингийн булан нэг нэг цохиод хугалаад аваад явчихаж байсан гэсэн.